65000 9	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	37	6	0	6
65001 1	Улс төрийн албан хаагч (УТ)	8	8	0	8

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Нэмэлт санхүүжилтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Т3 цэвэр дүн
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>56,797,898.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>56,797,898.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>51,656,659.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>7,139,000.00</b>
210104	Урамшуулал	7,139,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>2,567,040.00</b>
210402	Тээвэр, шатахуун	2,567,040.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>41,950,619.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	41,790,619.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	160,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>5,141,239.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>937,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	937,000.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>4,204,239.00</b>
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	4,204,239.00
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>52,643,807.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>52,643,807.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	46,334,019.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,259,788.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	50,000.00
<b>III</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	<b>-4,154,091.00</b>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,154,091.00

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тэшиг сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь “Нутаг дэвсгэрийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн төлөвлөгөөг орон нутгийн нөөц боломж, онцлог, улс аймгийн бодлого чиглэлтэй уялдуулан боловсруулж, төрийн шуурхай, ил тод, тэгш хүртээмжтэй үйлчилгээгээр хэрэгжилтийг хангаж ажиллана” гэсэн зорилгын доор таатай орчин, чанартай сургалт, шилдэг үйлчилгээг эрхэм зорилт болгон ажиллаж байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Монгол улсын үндсэн хууль, Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Архив бичиг хэргийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, НББ-ийн тухай хууль болон бусад тогтоол шийдвэрийг мөрдөн ажилласан байна.

Мөн Засгийн газрын "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 2021 оны 43 дугаар тогтоолоор төсвийн захирагч нарт төсвийг хэмнэлттэй зарцуулах үүрэг өгч ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй, аймгийн Засаг даргын 2020 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн А/424 тоот захирамжаар баталсан НБББББ-ийг мөрдөн ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудит, аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Тэшиг сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь дотоод аудит, аудиторгүй дотоод хяналт шалгалтын ажилтантай тус хяналт нь улиралд нэг удаа үйл ажиллагааны хяналт шалгалтыг хийж байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тэшиг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Тэшиг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 88.6 сая төгрөгөөр буюу 9 хувиар буурсан байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	407,867.8	570,307.2	162,439.3
Авлага	426,327.2	292,701.6	-133,625.6
Бараа материал	419,271.1	35,004.4	-384,266.7
Үндсэн хөрөнгө	4,995,602.1	955,515.1	-4,040,087.1
<b>Нийт хөрөнгө</b>	<b>6,249,068.4</b>	<b>1,853,528.4</b>	<b>-4,395,540.1</b>
Өр төлбөр	785,464.9	758,910.8	-26,554.1
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	5,463,603.5	1,094,617.6	-4,368,985.9
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>6,249,068.4</b>	<b>1,853,528.4</b>	<b>-4,395,540.1</b>

Дээрх хүснэгтээс харахад, 2022 он өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн дансны талаар товч тайлбарлан бичнэ.

Үндсэн хөрөнгийн хэмжээ өмнөх оноос 4,040.1 сая төгрөгөөр буурч, нийт хөрөнгө 4,395.5 сая төгрөгөөр буурсан нь Сургууль, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, Соёлын төв гэсэн байгууллагууд орон нутагт нэгтгэгдэхээ больсонтой холбоотой буурсан үзүүлэлттэй байна.

#### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 220.9 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 351.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнаж 130.5 сая төгрөгөөр өссөн байна.

#### Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

<i>/сая төгрөгөөр/</i>			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ ДҮН</b>	<b>407,867.8</b>	<b>570,307.2</b>	<b>-162,439.3</b>
<b>Банканд байгаа бэлэн мөнгө</b>	<b>407,851.1</b>	<b>570,111.5</b>	<b>-162,260.4</b>
<b>Төгрөг</b>	<b>16.8</b>	<b>195.7</b>	<b>-178.9</b>
Төрийн сангийн харилцах	381,740.1	545,474.3	-163,734.2
Арилжааны банк дахь харилцах	21,956.8	24,637.1	-2,680.2
Нэмэлт санхүүжилтийн харилцах	4,154.1		4,154.1
<b>Гадаад валют</b>			
Арилжааны банк дахь харилцах			
Замд яваа мөнгөн хөрөнгө			
<b>Дүн</b>	<b>407,867.8</b>	<b>570,307.2</b>	<b>-162,439.3</b>

Эх сурвалж: мөнгөн хөрөнгийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 545.4 сая төгрөг төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд үлдэгдэлтэйгээр тайлагнажээ.

#### Аудитын илрүүлэлт

Мөнгөн хөрөнгөтэй холбоотой гарсан зөрчил илрээгүй болно.

#### **3.5.2 Авлага**

Авлагын эхний үлдэгдэл 426.3 сая төгрөгийн, эцсийн үлдэгдэл 292.7 сая төгрөг болж 133.6 сая төгрөгөөр буурсан нь ЭМТ, Цэцэрлэг, Сургууль, Соёлын төв гэсэн байгууллагууд санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдээгүй хасагдсантай холбоотой байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

<i>/сая төгрөгөөр/</i>			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчтай холбогдсон авлага	50.0	359.9	309.9
Төлбөртэй үйлчилгээний авлага	161,918.8	0	-161,918.8
Татаас, санхүүжилтийн авлага			
Зээлийн хүүгийн авлага			
Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/	38.4	88.6	50.1
Татаас, санхүүжилтийн авлага			
Байгууллагаас авах авлага	33,917.8	7,797.5	-26,120.2
Хувь хүмүүсээс авах авлага	230,402.2	284,455.4	54,053.2
<b>Дүн</b>	<b>426,327.2</b>	<b>292,701.5</b>	<b>-133,625.6</b>

Эх сурвалж: Авлагын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх авлагаас ХХС-гийн данст 239.5, ЖДҮДС-гийн дансанд 7.2 сая төгрөгийн авлагууд тус тус эзэлж байна.

Дээрх авлагаас сумын ЖДҮ-ийг дэмжих сангаас авсан 2012-2019 оны насжилттай, 1.5 сая төгрөгийн зээлтэй 2 иргэн ор сураггүй хаяг тодорхойгүй байна.

#### Аудитын илрүүлэлт

ЖДҮ-ийн авлага 7,236,789 төгрөгийн авлагатай. Үүнээс 4 иргэний 6,721.8 мянган төгрөгийн зээл нь 2012-2019 оны насжилттай, 1.5 сая төгрөгийн зээлтэй 2 иргэн ор сураггүй хаяг тодорхойгүй байгаа тул олж тогтоож зээлийг төлүүлэх зөвлөмж өглөө.

#### **3.5.3 Урьдчилгаа**

Урьдчилгаа төлбөртэй холбоотой дансны авлага өглөг үүсээгүй болно.

#### **3.5.4 Бараа материал**

Бараа материалын эхний үлдэгдэл 419.2 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 35.0 сая төгрөг болж, 384.2 сая төгрөгөөр буурсан нь ЭМТ, Соёл, Сургууль Цэцэрлэгийн байгууллагууд орон нутагт нэгтгэгдэхгүй

болсонтой холбоотой байна.

*Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл*

<i>/сая төгрөгөөр/</i>			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Түүхий эд материал</b>	<b>59,021.8</b>	<b>1,875.3</b>	<b>-57,14.4</b>
Тусгай зориулалттай материал	0	0	0
Эм боох материал	55,830.9	70.1	-55,760.8
<b>Дуусаагүй үйлдвэрлэл</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>
<b>Бэлэн бүтээгдэхүүн</b>	<b>3,190.8</b>	<b>1,805.1</b>	<b>-1385.6</b>
<b>Хангамжийн материал</b>	<b>359,949.3</b>	<b>33,129.1</b>	<b>-326,820.2</b>
Бичиг хэргийн материал	11,974.4	7,212.5	-7,761.8
Аж ахуйн материал	39,134.7	11,571.8	-27,562.8
Сэлбэг хэрэгсэл	1,695.0	2,163.7	468.7
Түлш, шатах тослох материал	2,049.4	1,395.1	-654.3
Барилгын засварын материал	4,466.0	0	-4,466.0
Хүнсний материал	6,801.5	1,481.9	-5,319.5
Бусад хангамжийн материал	293,828.2	12,303.8	-281,524.3
<b>Мал амьтад</b>	<b>300.0</b>	<b>0</b>	<b>-300.0</b>
<b>Дүн</b>	<b>418,971.1</b>	<b>35,004.4</b>	<b>-383,966.7</b>

*Эх сурвалж: Бараа материалын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд бараа материалыг төсвийн хөрөнгөөр 129.03 сая төгрөгөөр худалдан авч, шилжүүлэн авсан 0.7 сая төгрөгийн бараа материалыг тус тус орлого авч тайлагнажээ.

**3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө**

Бусад эргэлтийн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэлгүй болно.

*Хүснэгт 6. Бусад эргэлтийн хөрөнгийн үлдэгдэл*

<i>/сая төгрөгөөр/</i>			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад			
Дүн			

*Эх сурвалж: .....*

*Аудитын илрүүлэлт*

**3.5.6 Үндсэн хөрөнгө**

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 13,283.3 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 8,754.5 сая төгрөг болж, 4,528.8 сая төгрөгөөр буурсан нь ЭМТ, Соёлын төв, сургууль, цэцэрлэг гэсэн төсөвт байгууллагууд салбар, салбарын нэгдсэн тайланд нэгдсэнтэй холбоотой байна.

*Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл*

<i>/сая төгрөгөөр/</i>			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Биет хөрөнгө</b>	<b>4794.4</b>	<b>959.9</b>	<b>-3834.5</b>
Барилга, байгууламж, орон сууц	10,382,870.8	6,902,399.3	-3,480,471.4
Авто-тээврийн хэрэгсэл	506,219.4	227,857.0	-278,362.4
Машин тоног төхөөрөмж(компьютер)	1,711,181.2	1,383,236.8	-327,944.4
Тавилга, аж ахуйн эд хогшил	333,519.1	59,378.4	-274,140.6
Номын фонд	19,974.5	0	-19974.5
Бусад үндсэн хөрөнгө	99,376.4	88,153.3	-11,223.1
Дуусаагүй барилга, байгууламж			
<b>Биет бус хөрөнгө</b>	<b>128.7</b>	<b>15.8</b>	<b>-112.7</b>
Программ хангамж	8,400.0	8,100.0	-300.0

Бусад биет бус хөрөнгө	22,1800.1	85,356.0	-136,444.1
<b>Бусад хөрөнгө /ТӨҮГ/</b>			
Хойшлогдсон татварын хөрөнгө /ТӨҮГ/			
Бусад эргэлтийн бус хөрөнгө /ТӨҮГ/ + Бусад			
<b>Дүн</b>	<b>13,283,341.7</b>	<b>8,754,480.9</b>	<b>-4,528,860.8</b>

Эх сурвалж: Үндсэн хөрөнгийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 54.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэж, 142.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг балансаас баланст шилжүүлэн авч, 296.8 сая төгрөгийн хөрөнгийг бусад орлогоор авч үндсэн хөрөнгийг нийт 493.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 5,022.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг хассанаар тайлагнасан нь эрүүл мэнд соёлын байгууллагууд нь харьяа салбартаа нэгтгэгдсэнтэй холбоотой байна.

Дуусаагүй барилга дансанд үлдэгдэл хөрөнгөгүй байна.

**Аудитын илрүүлэлт:**

Ахмадын өргөө, халуун ус барилга засвар, дотуур байр 80 ортой засварын зургийн "СТИЙЛ ПОРЕКТ" ХХК-иар хийлгэж зураг төсвийг мэргэжлийн байгууллагаар хянуулаагүй тул зөвлөмж өгсөн.

**3.5.7 Өр төлбөр**

Нийт өр төлбөрийн дансны эхний үлдэгдэл 48.9 сая төгрөгийн, эцсийн үлдэгдэл 22.4 сая төгрөг болж, 26.5 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	/ сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Татварын өглөг	15,280.2	8,123.7	-7,156.5
Байгууллагад төлөх өглөг	28,999.8	13913.8	-15,086.1
Ажилчидтай холбоотой өглөг	0	78.0	78.0
Хувь хүнд өгөх өглөг	502.8	253.7	-249.1
НДШ-ийн өглөг		41.3	41.3
Бусад			
<b>Дүн</b>	<b>48,964.6</b>	<b>22,410.5</b>	<b>-26,554.1</b>

Эх сурвалж: Өр төлбөрийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өглөгийг санхүүгийн тайландаа 22.4 сая төгрөгийн өглөгийн үлдэгдлээр тайлагнасан байна. Урт хугацаат өр төлбөрийн данс үлдэгдэлгүй болно.

**Аудитын илрүүлэлт:**

Өр төлбөртэй холбоотой алдаа зөрчил илрээгүй болно.

**3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг төсвөөс 607.7 сая төгрөг, үйл ажиллагааны орлогоос 1,075.2 сая, нийт зарлагыг 1,682.9 сая төгрөгөөр тооцон

төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Орон нутгийн төсвөөс 475.2 сая төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөсөн.

Төсвийн төслийн саналыг 1,682.9 сая төгрөгөөр өгсөн боловч тус саналаас зардлыг 205.1 сая төгрөгөөр нэмж 1,888.0 сая төгрөгөөр баталсан байна. Энэ нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй төлөвлөсөн боловч үндсэн хөрөнгө бэлтгэх саналыг хасаж, засгийн газрын тогтоолоор цалин нэмэгдсэн, оны эхний үлдэгдлийг нэмж баталсан шалтгаалаан нэмэгдсэн байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 46.3 сая төгрөгөөр бууруулж өөрчлөн баталсан байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 7 хөтөлбөрийг санхүүжүүлэхээр 1,888.0 сая төгрөгийг баталсан. Орон нутгийн төсвөөс 1,445.0 сая, үйл ажиллагааны орлогоос 443.0 сая төгрөгийг бүрдүүлэхээр байна. Орон нутгийн төсөв 1,577.0 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,577.0 сая төгрөг буюу 83.5 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 308.4 сая төгрөгөөр дутуу зарцуулсан нь Засаг даргын Тамгын газрын 2 төрийн албан хаагч оны эхэнд томилогдоогүй байсан цалин, нийгмийн даатгалын шимтгэл 8.5 сая төгрөг, сургуулийн түлш халаалтын зардалд шинээр ашиглалтад орох спорт залны халаалт 61.2 сая төгрөг, Засаг даргын Тамгын газрын төрийн хэмнэлтийн хуулиар цахимаар сургалтад оролцож 1.5 сая төгрөг, ОНХСангийн 4 төсөл арга хэмжээ дараа онд шилжиж 172.3 сая төгрөг тус тус зарцуулагдаагүйтэй холбоотой байна.

#### Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	ОН-ын өөрөө удирдах ёсны байгууллага /70105/	79,588.6	78,811.8	776.8	99%
2	ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага/70106/	681,635.2	602,692.8	78,942.4	88,4%
3	ОН нутгийн зорилтот Х/оруулалт /70503/	573,405.5	401,009.5	172,396.0	70%
4	Ерөнхий боловсрол /71802/	327,336.2	274,290.2	53,046.0	84%
5	Соёл урлаг /71702/	33,587.1	33,587.1	0	100%
6	Сургуулийн өмнөх боловсрол 71801	145,128.8	144,916.2	212,6	99,8%
7	Эмнэлэгийн тусламж үйлчилгээ	47,398.0	41,693.4	5,704.6	87,9%
<b>Нийт дүн</b>		<b>1,888,079.4</b>	<b>1,577,001.0</b>	<b>311,078.4</b>	<b>83,5%</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тэшиг сум нь 2022 оны санхүүгийн тайлангаар нэмэлт санхүүжилтийн дансаар 52.6 сая төгрөгийн орлого орж 56.7 сая төгрөгийн зарлага гарч үлдэгдэлгүй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тэшиг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангаар төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Тэшиг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитор Б.Энхтөр гүйцэтгэж, хяналтыг Аудитын менежер Ж.Энхцоодол, Дарга, Тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Тэшиг сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 01/35 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 1 хувиар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны бусад 2,865.9 сая төгрөгөөс 70 хувиар буюу 20.1 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага алба хаагчдын хурал цуглаан, сургалт семинарыг цахимаар зохион байгуулж үүнээс албан томилолтын зардал, шатахууны зардлыг хэмнэж ажилласан. Мөн байгууллагын дотоод сүлжээг ашиглаж байгууллагын бичиг хэргийн зардлыг хэмнэсэн зэрэг арга хэмжээ авч ажиллажээ.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

2022 оны Шилэн дансны мэдээллийг Шилэн дансны тухай хуулиар 154 мэдээлэл оруулахаас 2 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Зөвлөмж өгөв.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1.ЖДҮ-ийн авлага 7,236,789 төгрөгийн авлагатай. Үүнээс 4 иргэний 6,721.8 мянган төгрөгийн зээл нь 2012-2019 оны насжилттай, 1.5 сая төгрөгийн зээлтэй 2 иргэн ор сураггүй хаяг тодорхойгүй байгаа тул олж тогтоож зээлийг төлүүлэх.

Шийдвэрлэсэн нь:

1,500,000 төгрөгийн зээлтэй 2 иргэнийг олж тогтоож хууль хяналтын байгууллагат хүргүүлж зээлийг барагдуулах зөвлөмж өгөв.

2.ОНХС-аас Өтөг бууц цацагчийн сонгон шалгаруулалтыг шууд гэрээ байгуулахаар зарлаж 4 ААН үнийн санал ирүүлснээр ГИЙХ СОДОН ГЭРЭЛ" ХХК-г сонгож гэрээ байгуулж нийлүүлжээ. 4 газраас ирсэн үнийн санал баримтад хавсаргаж баталгаажуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Худалдан авалт хийсэн үнийн санал буюу Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь заалтыг мөрдөж бүрдлийг хангаж ажиллах зөвлөмж

3.ОНХС-гаас Ахмадын өргөө, халуун ус барилга засвар, дотуур байр 80 ортой засварын зургийн "СТИЙЛ ПОРЕКТ" ХХК-иар хийлгэж зураг төсвийг мэргэжлийн байгууллагаар хянуулаагүй.

Шийдвэрлэсэн нь:

Мэргэжлийн байгууллагаар хянуулж баталгаажуулж үлдэгдэл төлбөрийг олгох.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээллээс 2 мэдээг хугацаа хоцроож мэдээлсэн нь шилэн дансны хуулийн хэрэгжилт хангалтгүй байна

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 3 зөвлөмж 1 албан шаардлага хүргүүлж энэ хүү зөвлөж, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 01/132 тоот албан бичгээр биелэлтийг хангаж ажиллажээ.

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Тэшиг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй байна.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 3 зөвлөмж 1 албан шаардлага хүргүүлж энэ хүү зөвлөж, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 01/132 тоот албан бичгээр тогтоосон хугацаанд биелэлтийг хангаж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	11,289,000	1	11,289,000	100
Албан шаардлага	0	0	0	0	0
Зөвлөмж	0	0	0	0	0
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>11,289,000</b>	<b>1</b>	<b>11,289,000</b>	<b>100</b>

/мянган төгрөгөөр/

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

ЖДҮ-ийг дэмжих сангийн олон жилийн насжилттай зээлийг барагдуулах, ОНХС-гаар хийгдсэн ажлыг мэргэжлийн хяналтын байгууллагаар хянуулж хүлээж авах, тендертэй холбоотой анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

---

Аудитаар нийт 4.9 сая төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс, 1.3 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 3.6 сая төгрөгийн 6 зөвлөмж өгсөн.

Үүнээс хууль хяналтын байгууллагат шилжүүлсэн, хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлээгүй байна.

#### 5.1 Төлбөрийн акт

Бүртгэлтэй нийт 160 иргэний галт зэвсгийн албан татвар 8,220,000 төгрөгийн татвар ноогдуулахаас 7,085,600 төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 6,866,000 төгрөгийг төвлөрүүлж 1,354,000 төгрөгийг дутуу төвлөрүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1 дэх "Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ" 41.2.1 дэх "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" заалтыг мөрлөж ажиллах.

#### 5.2 Албан шаардлага

Албан шаардлага бичигдээгүй.

#### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 1. ЖДҮ-тэй холбоотой асуудал

Илрүүлэлт: /Нөхцөл байдал, үр дагавар, нийцээгүй хууль тогтоомж, стандартын заалтыг бичих/

ЖДҮ-ийн авлага 7,236.7 мянган төгрөгийн авлагатай. Үүнээс 4 иргэний 6,721.8 мянган төгрөгийн зээл нь 2012-2019 оны насжилттай, 1.5 сая төгрөгийн зээлтэй 2 иргэн ор сураггүй хаяг тодорхойгүй байгаа тул олж тогтоож зээлийг төлүүлэх.

Өгсөн зөвлөмж:

1,500.0 мянган төгрөгийн зээлтэй 2 иргэнийг олж тогтоож хууль хяналтын байгууллагат хүргүүлж зээлийг барагдуулах

##### 2. ОНХС-тай холбоотой асуудал

Илрүүлэлт: /Нөхцөл байдал, үр дагавар, нийцээгүй хууль тогтоомж, стандартын заалтыг бичих/

Өтөг бууц цацагчийн сонгон шалгаруулалтыг шууд гэрээ байгуулахаар зарлаж 4 ААН үнийн санал ирүүлснээр ГИЙХ СОДОН ГЭРЭЛ" ХХК-г сонгож гэрээ байгуулж нийлүүлжээ. 4 газраас ирсэн үнийн санал баримтад хавсаргаж баталгаажуулаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Худалдан авалт хийсэн үнийн санал буюу Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь заалтыг мөрдөж бүрдлийг хангаж ажиллах

##### 3. ОНХС-тай холбоотой асуудал

Илрүүлэлт: /Нөхцөл байдал, үр дагавар, нийцээгүй хууль тогтоомж, стандартын заалтыг бичих/

Ахмадын өргөө, халуун ус барилга засвар, дотуур байр 80 ортой засварын зургийн "СТИЙЛ ПОРЕКТ" ХХК-иар хийлгэж зураг төсвийг мэргэжлийн байгууллагаар хянуулаагүй.

---

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**Өгсөн зөвлөмж:**

Мэргэжлийн байгууллагаар хянуулж баталгаажуулж үлдэгдэл төлбөрийг олгох.

**4. Улсын тэмдэгийн хураамжтай холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** /Нөхцөл байдал, үр дагавар, нийцээгүй хууль тогтоомж, стандартын заалтыг бичих/

Улсын тэмдгийн хураамж нь 7,500.0 мянган төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 5,776.1 мянган төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөнөөс 1,723.9 мянган төгрөгөөр тасарсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1 дэх "Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ" 41.2.1 дэх "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" заалтыг мөрлөж ажиллаагүй.

**Өгсөн зөвлөмж:**

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1 дэх "Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ" 41.2.1 дэх "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" заалтыг мөрлөж ажиллах.

**5. Хог хаягдлын хураамжтай холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** /Нөхцөл байдал, үр дагавар, нийцээгүй хууль тогтоомж, стандартын заалтыг бичих/

Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг 5,500.0 мянган төгрөгөөр төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 5,079.5 мянган төгрөгийг төвлөрүүлж төлөвлөгөөг 420.4 мянган төгрөгөөр тасарсан нь ТУН Системд 2022.12.30-ны үдээс өмнө хийгдсэн боловч сангийн яамны гүйлгээ таталт хийгдээгүй сар дамжаж замд яваа орлогоор орсон тул төлөвлөгөө гүйцэтгэл 5,524.5 мянган төгрөг орж биелэлт 100.4 хувьтай байна.

**Өгсөн зөвлөмж:**

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1 дэх "Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ" 41.2.1 дэх "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" заалтыг мөрлөж ажиллах.

**6. Шилэн данстай холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** /Нөхцөл байдал, үр дагавар, нийцээгүй хууль тогтоомж, стандартын заалтыг бичих/

Нийт 154 мэдээлэл оруулахаас 2 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна

**Өгсөн зөвлөмж:**

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

		/мянган төгрөгөөр/
	Нийт зөрчил	Үүнээс

Зөрчлийн товч утга			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тэшиг сумын ТТЗ	3	3,498.3	1	1,354.0			2	2,114.3				
ЖДҮ	1	1,500.0					1	1,500.0				
ОНХС	2	0					2	0				
<b>Дүн</b>	<b>6</b>	<b>4,998.3</b>	<b>1</b>	<b>1,354.0</b>			<b>5</b>	<b>3,614.3</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Шилэн данс	1	0					1	0
Дүн								
Нийт дүн		10					1	0